



НҮБ-ын Хүүхдийн
Сан
Монгол



Хүйсийн тэгш
Эрхийн төв



Дэлхийн Зөн
Монгол

**“Хүн худалдах гэмт хэрэг ба охид
эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөг”
судалгааны товч тайлан**

Улаанбаатар хот 2007 он

Судалгааны санхүүжүүлэгч

НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол
Дэлхийн Зөн Монгол,

Судалгааг хэрэгжүүлэгч

Хүйсийн тэгш эрхийн төв
Сонгогдсон судалгааны баг (ЦЕГ-
ын Эрүүгийн цагдаагийн газар,
Улсын Мөрдөн байцаах газар,
Интерполын Монгол дахь товчоо,
МУИС-ын ХАССТ)

Судалгаанд хамрагдсан газрууд

Улаанбаатар хот
Чойбалсан хот
БНХАУ-ын Бээжин
Макао
ГонКонг
БНСУ

Дэлхийн улс орнуудыг ХХГХ-тэй хэрхэн тэмцэж байгаа байдал, гэмт хэргийн гаралт, хэмжээ, уг гэмт хэргийг таслан зогсоохын тулд юу хийж байгаагаар нь ангилсан байна. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга өнгөрсөн зургадугаар сард Конгрестоо тавьсан илтгэлдээ Монгол улсыг “В” ангилалд багтаажээ¹. “В” ангилалд энэ гэмт хэрэгтэй тэмцэж байгаа боловч урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, хууль тогтоомж оновчтой биш, цэгцтэй хөтөлбөр, бодлогогүй хэмээх орнуудыг хамруулдаг юм байна.

ХХГХ-ийн 75 орчим хувийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдах хэлбэр эзэлдэг ажээ². Хөгжиж байгаа орны хүүхэд, эмэгтэйчүүдийг улсын дотор, хөрш зэргэлдээ улс руу болон Ази, Европын хөгжингүй орнууд руу өндөр цалинтай ажилд зуучлах, гэрлүүлэх зэргээр хуурч мэхлэн, хууль бус орогнол, бичиг баримтын зөрчил, мөнгөгүй, хэл мэдэхгүйн улмаас тусламж авах бололцоогүй байдлыг ашиглан эрхшээлдээ оруулж, биеийг нь үнэлүүлж орлого олж байна³.

¹ Өнөөдөр сонин, №196 (2545) 2005.08.22

² Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр, 2005 оны 11 сарын 30, 234-р тогтоолын 1-р хавсралт

³ Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр, 2005 он

Хүн ам цөөтэй, хүн амын 70 гаруй хувийг 35 хүртэлх насны хүүхэд, залуучууд эзэлдэг орны хувьд Засгийн газраас “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр” батлан гаргасан нь цаг үеэ олсон үйл ажиллагаа бөгөөд энэхүү хөтөлбөрөө хэрэгжүүлэх, ХХГХ-ийг үндэсний аюулгүй байдалд ч нөлөө үзүүлэхүйц хэмжээний асуудал болохоос урьдчилан сэргийлж, иргэн нэг бүрийнхээ эрх ашгийг хамгаалах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Судалгааны зорилго, зорилтууд

Энэхүү хохирогчдын бодит байдалд тулгуурлан НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн зөн Монгол ОУБ, Хүйсийн тэгш эрхийн төвийн санаачлагаар Монгол охид, эмэгтэйчүүд хүн худалдах гэмт хэргийн хохирогч болж буй эсэх, тэд энэ гэмт хэргийн ямар хэлбэрт илүү их өртөж байгаа, тэдний ажлын нөхцөл, эрүүл мэнд, аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа талаар нарийвчлан судалж, цаашид энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах, нөхөн сэргээх талаар санал, зөвлөмж гаргах зорилгоор үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ.

Судалгааны зорилтууд:

1. Гадаадад албадлагаар биеэ үнэлж байгаад ирсэн болон одоо гадаадад (ялангуяа Бээжин, Макао, Хон-Конг, БНСУ) бэлгийн мөлжлөгт өртөж, хүчинд автан биеэ үнэлж байгаа охид, эмэгтэйчүүд болон гадаадын (БНСУ) иргэдтэй гэр бүл болсон хүн худалдах гэмт хэргийн хохирогч болсон охид, эмэгтэйчүүд;
 - Хүн худалдах гэмт хэрэгт өртөөд байгаа болон өртсөн охид, эмэгтэйчүүдийн нөхцөл байдал ялангуяа, тэдний санхүүгийн байдал, эцэг эх, гэр бүлийн харьцаа, хүчирхийлэл, доромжлол, бэлгийн болон санхүүгийн мөлжлөг, ахуйн болон ажлын нөхцөл байдал, эрүүл мэнд, тусламж дэмжлэг болон ирээдүйн талаар тодруулах;
 - БНСУ-д амьдарч байгаа Солонгос иргэдтэй гэр бүл болсон охид, эмэгтэйчүүдийн гадаад шилжилт, санхүүгийн байдал, гэрлэлт, хүндрэл бэрхшээл, доромжлол, шийтгэл, эрүүл мэнд болон ирээдүйн талаар тодруулах;
2. Хүн худалдах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй бүлэг:
 - Охид, эмэгтэйчүүдийн хүн худалдах гэмт хэргийн талаарх мэдлэг, хандлагыг тодруулах;

- Хүн худалдах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй бүлгийн охид, эмэгтэйчүүдийн гадаад шилжилт ялангуяа, гадаадад ажил эрхлэх боломжийг хэрхэн хүлээн авч байгаа байдал, энэ талаарх мэдээллийг олж авч байгаа эх үүсвэрийг тодруулах;
- Хүн худалдах гэмт хэрэгт өртөх хамгийн их эрсдэлтэй бүлгийг дотоодод биеэ үнэлж байгаа охид, эмэгтэйчүүд, халамжийн төвийн хүүхдүүд, ажил идэвхтэй хайж буй хүмүүс, бага цалинтай хүмүүс гэх мэт эрсдэлтэй бүлгүүдээс тодруулан гаргах;

Монгол Улс дахь Хүн худалдах гэмт хэргийн нөхцөл байдал

Монгол улсад охид, эмэгтэйчүүдийг гадаад, дотоодод хүчээр бэлгийн мөлжлөгт ашиглах, гадаадын иргэдтэй гэрлүүлэх, насанд хүрээгүй хүүхдээр хулгай хийлгэх хэлбэрүүд илүү зонхилж байна.

Охид, эмэгтэйчүүдийг элсүүлэхдээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр боломж амалсан зар тавьж эсвэл танил талын холбоогоо ашиглан ихэнх тохиолдолд бичиг баримт, зардалд туслан гадаадад хийх ажил, амьдралын талаар худал мэдээлэл өгч хамтдаа харийг зорьдог байна. Эдгээр элсүүлэгчид дийлэнхдээ нэг хохирогчийг дунджаар 100-500ам.доллараар зуучлагчид хүргэн өгдөг ба зуучлагчид эдгээр охид эмэгтэйчүүдийг худалдан авагчдад 1000-3500 ам.доллараар зарж ашиг олдог байна.

Монгол улсад хүн худалдах гэмт хэргийг үйлдэж байгаа хүмүүсийн дийлэнхи урд нь ХХГХ-ийн хохирогч болж байсан эмэгтэйчүүд байна.

МОНГОЛ УЛСАД ҮЙЛДЭГДЭЖ БҮЙ ХХГХ-ийн ХЭЛБЭРҮҮД

1. Бэлгийн мөлжлөг

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад аялал, жуулчлалын салбар эрчимтэй хөгжиж байгаа болон Ази руу чиглэсэн секс жуулчлалын урсгалыг дагаад биеэ үнэлэх, бусдыг бэлгийн мөлжлөгт ашиглан ашиг олох явдал өсөн нэмэгдэж байна.

Хохирогчдыг ихэнх тохиолдолд гадаад, дотоодын “янхны газруудад”, эрүүл мэнд, амь насанд нь аюултай газарт ажиллуулдаг. Мөн зочид буудал, саунд “массажист”, караоке бааранд “ширээний үйлчлэгч”, диско клубт “бүжигчин” нэрээр далдлан биеийг нь албадан үнэлүүлж, бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашигладаг ажээ. Түүнчлэн дотоодод охид, эмэгтэйчүүдийг хөлсний байр, зочид буудалд хорьж бэлгийн мөлжлөгт ашиглаж байна.

2. Хуурамч гэрлэлт

Монгол улсад гадаадын иргэдтэй гэрлэж байгаа иргэдийн 95 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаагаас БНСУ-ын иргэдтэй гэрлэх явдал хамгийн өндөр (65%) хувийг эзлэж байна.

Гэрлэлтийг зуучлагчид албан ёсны зөвшөөрөлгүй, байгууллага, хувь хүмүүс байдаг. Охид, эмэгтэйчүүдийг элсүүлэхийн тулд тэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр боломж амалсан зарыг⁴ тасралтгүй гаргадаг байна. Гэрлэх хугацаа нь зуучлах албанд хандсанаас хойш 1-3 сарын хугацаатай байдаг ба гэрлэх гэж буй хүнтэйгээ /нөхөр/ 1-2 удаа уулздаг ба эсвэл огт уулзахгүйгээр гэрлэдэг ажээ.

Хүснэгт 1: Гадаадын иргэдтэй гэр бүл болж бүртгүүлсэн хүний тоо

Улсын нэр	Бүртгүүлсэн хүний тоо	Үүнээс: эмэгтэй	
		Тоо	Эзлэх хувь
БНСУ	1668	1648	98.8
Япон	119	99	83.2
БНХАУ	137	130	94.9
Герман	155	152	98.0
ОХУ	65	26	40.0
АНУ	89	77	86.5
Дүн	2233	2132	95.0

Эх сурвалж: ИБМУТ, 2005 он

⁴ “Дундаас дээш амьдралтай, санхүүгийн боломжтой гадаадын иргэдтэй гэрлүүлнэ” гэсэн зарыг хэвлэл мэдээллийн бүх хэрэгслийг ашиглан гаргадаг.

Охид, эмэгтэйчүүд баян чинээлэг гадаад хүнтэй гэрлэж амьдрах, мөн ажил хийж их мөнгө олох хүсэлдээ автан “хуурамч гэрлэлт”-нд итгэж, тухайн орныг зорьдог. Тэдний олонхи тухайн оронд очсоныхоо дараа хотоос алслагдсан хөдөө тосгонд хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт ажил эрхлэн “боол” мэт нөхцөлд ажиллаж амьдарч байна.

3. Хүчээр хулгай хийлгэх

Насанд хүрээгүй хөвгүүд, ялангуяа хараа хяналтгүй, эцэг эхгүй хүүхдийг сонгон хуурамч бичиг баримт бүрдүүлэн харь оронд аваачиж хүчээр хулгай хийлгэдэг байна. Өнгөрсөн хугацаанд (2002 оноос хойш) Хүйсийн Тэгш Эрхийн Төвд энэ шалтгаанаар хоёр хүүхэд, Цагдаагийн газарт мөн хоёр хүүхдийн хэрэг бүртгэгдсэн байна. Харамсалтай нь тухайн хүүхдийг бусдын бичиг баримтыг ашиглан “хавсралт”-аар⁵ хил нэвтрүүлдэг. Тэднийг дарамтлан, хүчээр хулгай хийлгэдэг хүмүүс тухайн хүүхдийг цагдаа, хууль хяналтын байгууллагад баригдвал тухайн газартаа (ихэнх тохиолдолд хилийн чанадад) орхин ор сураггүй алга болдог.

⁵ МУ-ын насанд хүрээгүй хүүхдүүд дөрвөн төрлийн бичиг баримтаар хил нэвтэрдэг. Бие даасан паспорт, эцэг эх, асран хамгаалагчийн паспортан дээр зураг наалгах, хил орчмын цагаан хуудсанд хамтран гарах, эцэг эх, асран хамгаалагчийн паспортанд итгэмжлүүлэн хавсралт хуудас авч хил нэвтэрдэг.

ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ ХҮН ХУДАЛДАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧДЫН АСУУДЛУУД

Энэхүү судалгаанд Бээжин хот, Хонг-Конг, Макао, БНСУ-д ХХГХ-ийн бэлгийн мөлжлөгт өртсөн нийт 48 эмэгтэйчүүд хамрагдсан ба насны байдлаар авч үзвэл тэдгээрийн дийлэнх 18 ба түүнээс дээш насныхан байлаа.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдагсад насны бүлэг, улсаар

Улсын нэр	Насны бүлэг				Бүгд
	16-17 нас	18-19 нас	20-22 нас	23-25 нас	
Бээжин хот	1	3	3	1	8
Хонг-Конг	1	2	3	2	8
Макао	2	8	12	6	28
БНСУ	-	-	2	2	4
Бүгд	4	13	20	11	48


Судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн дийлэнх буюу 79.3 хувь огт гэрлээгүй, 17.2 хувь нөхрөөсөө салсан хүмүүс байна. Гурван хүн тутмын нэг их, дээд сургуульд суралцаж байгаад сургуулиа орхижээ.

Судалгаанд оролцогчдын 52 хувь гэр бүлийнхээ амьдралд нэмэр болох, 25 хувь боловсролдоо зориулж мөнгө олох, 23 хувь санхүүгийн хувьд бусдаас хараат бус болохын тулд гадаад орныг зорьсон байна.

Зуучлагчдын ихэнх өөрсдөө ХХГХ-ийн хохирогч болж байсан эмэгтэйчүүд байсан бөгөөд тэд охид, эмэгтэйчүүдийн гадаадын улс руу явах зардлыг даан авч яваад, дараа нь цалингаас нь бага багаар суутгаж төлүүлэхээр тохирч, гадаад паспорт, бичиг баримтыг бүрдүүлж “**туслалцаа**” үзүүлнэ гэсэн тохиролцоог хийдэг байжээ.

Түүнчлэн зуучлагчид охид, эмэгтэйчүүдэд 500-3000 ам.долларын буюу өндөр цалинтай, гадаад дахь монгол зоогийн газар эсвэл загвар өмсөгч, гоо сайханч, бүжигчин, массажистын ажлуудыг хийлгэнэ гэсэн хуурамч санал тавьсанаар тэд хилийн дээс алхацгаажээ.

Зуучлуулагчдын 96 хувь нь тухайн улсад очсоныхоо дараа хийх ажлынх нь талаар худал мэдээлэл өгч байсныг эцсийн мөчид мэдэж, зуучлагчдаа бичиг баримтаа хураалган 1500-3500 ам.долларын барьцаанд орсноор хүчинд автан, биеэ үнэлэхээс өөр аргагүйд хүрдэг байна.

Зураг 1. Гадаадад явах талаарх мэдээллийн эх үүсвэр

Хохирогч таван хүн тутмын нэг нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан “өндөр, царайлаг, 25 хүртэлх насны охидыг гадаадад өндөр цалинтай ажилд зуучилна” гэсэн утга бүхий зарын дагуу зуучлагчид хандсан байлаа.


Охид, эмэгтэйчүүдээс өртэй эсэх талаар тодруулахад бүгдээрээ өртэй гэсэн хариултыг өгсөн боловч тэдний тал хувь нь яг хэдий хэмжээний өртэйгээ мэдэхгүй, зарим нь өдөрт 800 юань (эсвэл хон-конг доллар) төлдөг гэдгээс өөр мэдэх зүйлгүй байсан. Харин нэг охин өрөө дарж дуусаад байгаа гэж хариулж байлаа.

Тухайн улсад очихдоо болон тэнд амьдрах хугацаандаа зарцуулсан тээврийн зардал, хувцас, хувийн хэрэглээнүүд нь тэдний өр, өрийн хүүн дээр нэмэгдэж тооцогддог байна. Ажил олгогчид нь тэднийг өрнөөс салгах дургүй бөгөөд “**мөнгөний машин**” мэт ашиглах зорилготой байдаг ажээ.

Судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн хувьд ажлын нөхцөл хүнд, шөнийн цагаар ажиллах, үйлчлүүлэгчийн хүссэн бүх үйлчилгээг хийх, бүр зарим тохиолдолд амьд явах баталгаа ч байхгүй эрсдэлтэй нөхцөлд ордог нь хохирогчдын сэтгэл санааны дарамтыг улам нэмэгдүүлдэг байна. Ажил олгогчоос тэдний ажил үүргийг сайтар “ухамсарлуулж”, “үйлчлүүлэгчийг дахин ирж үйлчлүүлэх таатай сэтгэгдэл бий болгох” –ыг гол шаардлага болгодог.

Бээжин хотын Холливуд, Дэн, Элефант, Магис диско клубүүд нь тэнд ажиллаж буй монгол охид, эмэгтэйчүүдийн өрөө дарах гол “ажлын байр” нь болдог. Тэд оройн цагаар диско клубээр явж үйлчлүүлэгчээ өөрсдөө олж, олсон орлогоороо өрөө дардаг бөгөөд зарим үед дуудлагаар явж үйлчилгээ үзүүлдэг ажээ. Тэдэнд аюулгүй байдлын ямар ч хамгаалалт байхгүйгээс гадна зодуулж, дарамтлуулан ямарч хөлс авч чадахгүй байх тохиолдол багагүй гардаг юм байна.

Зураг 2. Монгол охид, эмэгтэйчүүдийн ажиллаж буй үйлчилгээний салбар



Харин Хон-Конгод байгаа монгол охид, эмэгтэйчүүд Tsim Shi Tsai орчмын буудлаар, гудамжинд зогсож, мөн Tsim Sha tsai гудамж, Strawberry, Big apple, Joe banana, Naptna, Centuria шөнийн цэнгээний газруудад ажилладаг бол Макао ажиллаж буй охид, эмэгтэйчүүд ихэвчлэн саунд ажилладаг юм байна.

Монгол охид, эмэгтэйчүүд Макао орой 8 цагаас өглөөний 6 цаг хүртэл саунд ажилладаг. Ихэвчлэн дотуур хувцасны гадуур гэрэлтдэг даашинз, нөмрөг маягийн юм өмсөж зочдын урд “шоу”-нд гардаг. Үйлчлүүлэгчдийн өмнө бүжиглэж, тэднээр өөрийгөө сонгуулах үйлдлийг хийдэг. Хүн бүр хувийн дугаартай байдаг тул үйлчлүүлэгч дугаараар нь дуудаад л авдаг. Тэд үйлчлүүлэгчтэй хамт саун, бассейнд хамт орж, тусгайлсан өрөөнд үйлчлүүлэгчийн хүссэн бүх үйлчилгээг үзүүлдэг. Саун, массажны газрууд дотроо зориулалтын тусгайлсан өрөөнүүдтэй тул гадагшаа гарах шаардлагагүй.

Архи, хар тамхи хэрэглэсэн үйлчлүүлэгчид охид эмэгтэйчүүдийг зодох /92 хувь/, цохих, мөнгөө өгөхгүй элдвээр доромжилж дарамтлах тохиолдол элбэг гардаг. Охид, эмэгтэйчүүдийг хэл амаар доромжилж гутаах, айлган сүрдүүлэхийг бараг үйлчлүүлэгч бүр гаргадаг бол амь насыг нь хөнөөхөөс наахнуур зодож бах таваа хангадаг садист хүмүүс ч /23%/ таардаг тухай ярьж байлаа.

Макао монгол охид, эмэгтэйчүүд ажил олгогчоос өгсөн нэг өрөөнд 4-10-уулаа амьдардаг ба энэ байр нь ихэвчлэн ажлын газартай ойр байрлаж “мадам” буюу эзэгтэйн хяналтан доор байдаг. Өр төлөгдөж дуусаагүй бол ганцаараа гадагшаа гарахыг зөвшөөрдөггүй. Мөн “мадам” охид, эмэгтэйчүүдтэй хамт нэг байранд байх нь түгээмэл бөгөөд ингэснээр тэднийг хяналтандаа байлгах боломжтой болдог байна.

Хон-Конгод ажлаа тасалж, хоцорвол цалингаа хасуулах, мөнгөн торгууль төлөх, зодуулах, амралтын өдөргүй ажиллах зэргээр шийтгүүлдэг. Харин шоунд гарахаасаа татгалзвал 1000-2000 Н\$ -оор (150-250 ам.дол) торгодог бичигдээгүй хуультай.

Судалгаанд хамрагдагсдын олонхи /78 хувь/ сэтгэлийн зовлон, гутралаа даван туулахын тулд согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх аргыг сонгодог болсон тухайгаа ярьж байлаа.

Монгол охид ажил олгогч болон үйлчлүүлэгчийн таашаалд бүрэн нийцэж байх ёстой гэсэн зарчим дээр ажилладаг байна. Тодруулбал, шинэ ирсэн охидыг тураах эм уулган хоолыг нь сойж, хүчээр хөхийг нь томруулан нүдэнд нь давхраа хийдэг бөгөөд төлбөрийг дараа цалингаас суутгадаг байна. Жишээ нь: охид, эмэгтэйчүүдийн хөхөнд гель шахуулахад 1000 ам.доллар, давхраа 50-100 ам. доллар гэх мэт.

Судалгаанд хамрагдагсдын 85 хувь эх орондоо очихыг хүсэж байгаа боловч зардалгүй, өрөө төлж дуусаагүй, бичиг баримтгүй зэрэг шалтгаанаар буцаж чадахгүй байгаа. Мөн нэлээд хэсэг нь гэртээ гар хоосон очихоос зүрхшээж, өрөө хурдхан дарж дуусгавал үлдсэн хугацаанд нь өөртөө зориулж мөнгө хуримтлуулахыг хүсдэг байна.


Охид, эмэгтэйчүүдийн 78 хувь боловсролдоо зориулж мөнгө хадгалах, эх орондоо очоод сурч байсан сургуульдаа үргэлжлүүлэн сурах, шинээр боловсрол, мэргэжил эзэмшихийг хүсч байна гэжээ.

ЭХ ОРОНДОО БУЦАЖ ИРСЭН ХОХИРОГЧИЙН АСУУДАЛ

Судалгаанд гадаадад албадлагаар биеэ үнэлж байгаад эх орондоо буцаж ирсэн 16 хохирогч хамрагдсан. Тэдний тал хувь нь 20-22 насныхан эзэлж байгаа ба насанд хүрээгүй хүүхэд нэг байсан нь сургуулиас завсардсан охин байлаа.

Судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн талаас илүү хувь бүрэн дунд боловсролтой. Гурав нь их, дээд сургуулиа орхисон, зөвхөн ганц хүн л дээд сургууль төгссөн байв.

Зураг 3. Гадаадад ажиллахаар шийдсэн шалтгааны хувь



Гадаадад ажиллах тухай мэдээллийг гурван эмэгтэй тутмын хоёр нь найз нөхөд, таньдаг хүмүүсээсээ, үлдсэн хэсэг нь /31хувь/ хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр гарсан зараас олж авчээ.

Судалгаанд хамрагдсан охидын тал хувь нь гадаад улсад ажиллахаар явахдаа 100-500 ам.долларыг төлсөн бол үлдсэн зардлыг зуучлагчид нь даасан байлаа. Гэвч хэдий хэмжээний зардал гаргасныг хохирогчид мэдэхгүйгээр 1000-3000 ам.долларын өр төлөх ёстой болсон байна.

Монголоос явахдаа охид, эмэгтэйчүүд сард 2000-3000 ам.долларын цалин авахаар зуучлагчтайгаа тохиролцдог боловч 60 гаруй хувь нь ямар ч цалин авалгүй өрөө дарсаар байгаад иржээ. Харин 20 гаруй хувь нь сард 200-300 долларын цалин авч байсан боловч ахуйн хэрэглээ, хоол хүнсэндээ зарцуулаад дуусдаг байсан ажээ.

Зураг 4. Гадаадад ажиллаж байгаад ирсэн охид, эмэгтэйчүүдийн тоо, ажиллаж байсан газраар



Дээрх ажлуудыг хийснээр эрүүл мэнд муудсан гэж хоёр хохирогч тутмын нэг үзжээ. Тухайлбал, сарын тэмдэг зогсоох, тураах эм байнга хэрэглэх, сэтгэл санаагаа тайвшруулж, хүнд хэцүү байдлаа даван туулахын тулд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэдгээс эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн гэжээ.

Гурван хохирогч тутмын нэг тухайн газарт очоод ажлын нөхцөл нь анх тохиролцсоноос өөрчлөгдсөн гэжээ. Охид, эмэгтэйчүүдийг анх элсүүлэхдээ бааранд бүжигчин, массажист, загвар өмсөгч хийлгэнэ гэж байсан байна. Бусад охидод нь биеэ үнэлэх тухай хэлж байсан боловч их мөнгө олох боломжтой, эрх чөлөөтэй, сайхан орчинд байна гэх мэтээр хуурч мэхлэн аваачиж өрийн барьцаанд оруулан бичиг баримтыг нь хураан авсан байна.

Эдгээр охид, эмэгтэйчүүдээр саун, массажны газар массажист, караоке бааранд ширээний хүүхэн, диско бааранд үйлчлэгч хийлгэдэг байсан ба энэ нэрийн дор үйлчлүүлэгчийн хүссэн үйлчилгээг үзүүлдэг байсан тухайгаа ярьцгааж байлаа. Тэд богино хугацаанд өрөө дарж дуусгахын тулд аргагүйн эрхэнд хүчинд автан биеэ үнэлэгчийн ажил хийх болсон ба бусдын хяналт, дарамтанд бичиг баримтгүй, өртэй, хэлний бэрхшээлээс шалтгаалан ажлаа өөрчилж чадалгүй байсаар эх орондоо ирцгээжээ.

Тэдэнд чөлөөт цаг гэж байгаагүй. Ихэвчлэн 15.00-03.00 цаг хүртэл ажиллаж, сарын тэмдгээ ирсэн үед л нэг удаа амрах зөвшөөрөлтэй байжээ. Зарим эмэгтэйчүүдэд (9 хүнд) нутаг буцахад нь 200-300 ам.долларын цалин өгч, үлдсэнийг нь ажил олгогчид ерөндөө суутгасан тухайгаа мэдэгдсэн байна..


Манжуурт худалдагдсан хохирогчид оргож, нэгэн монгол хүний тусламжтайгаар эх орондоо эргэж ирсэн боловч хууль хяналтын байгууллагад хандаж чадаагүй байна. Тэд хуулийн байгууллагын ажилтнууд нууцыг хадгална гэдэгт итгээгүй бөгөөд биеэ үнэлж байсан

нь жижиг газар учир хурдан түгэж, ирээдүйд нь сөргөөр нөлөөлнө гэж болгоомжилсноос ийнхүү хандаагүй байна.

Судалгаанд хамрагдагсад үйлчлүүлэгчдийн 70-80 хувь нь хятад бусад нь солонгос, япон, вьетнам, баруун европын орнуудынхан байдаг тухай ярьж байсан ба тэд үйлчлүүлэгчид яаж бэлгийн үйлчилгээ үзүүлэх талаар өмнө нь тусгайлсан сургалтанд хамрагдсан гэжээ.

Охид, эмэгтэйчүүд бэрхшээл тохиолдоход болон сэтгэл санаагаа тайвшруулахын тулд тогтмол согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэдэг байжээ. Тэдний олонхи нь (70 гаруй хувь нь) найзууд, хамтран ажиллагсдынхаа, тал хувь нь үйлчлүүлэгчдийнхээ дэмжлэгт найдаж бэрхшээлийг даван туулж иржээ.

5. Хохирогчдын ирээдүйн талаарх бодол



ГАДААДЫН ИРГЭДТЭЙ ГЭР БҮЛ БОЛОХ АСУУДАЛ

БНСУ-д амьдарч байгаа Солонгос иргэдтэй гэр бүл болсон 30 охид, эмэгтэйчүүдээс энэхүү судалгааг авсан. Насны хувьд судалгаанд хамрагдагсад харьцангуй залуу, дундаж нас 24.9 байхад харин тэдний нөхрийн дундаж нас 44.5 буюу дунджаар 20 насаар ахимаг байлаа.

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүд болон нөхрийн нас

Хүйс	Насны бүлэг						
	18-19	20-24	25-29	35-39	40-44	45-49	50+
Эмэгтэй							
тоо	2	9	19				
хувь	6.7	30.0	63.3				
Нөхөр							
тоо				5	5	16	4
хувь				16.7	16.7	53.3	13.3

Судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн 56.3 хувь нь нөхрийнхөө боловсролын түвшин болон мэргэжлийг хэлж мэдэхгүй байсан ба үлдсэн хариулагчдын 1/3 нь нөхрийгөө ямар нэгэн мэргэжилгүй, ажилчин гэж хариулсан. Харин нөхрийнхөө боловсролын түвшинг “мэддэг” гэж хариулсан охид, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин солонгос нөхрийнхөөсөө дээгүүр байв.

Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүд болон тэдний нөхрийн хувь, боловсролын түвшингээр

	Боловсролын түвшин						
	Бүрэн бус дунд	Сургууль завсардсан	Бүрэн дунд	Их, дээд сургууль төгссөн	Их, дээд сургууль-лиас гарсан	Мэдэхгүй	Нийт
Эхнэр			58.8	29.4	11.8		100
Нөхөр	25.0	6.3	6.3	6.3		56.3	100

Гадаадад ажиллаж амьдрахад хэлний мэдлэг ялангуяа тухайн оршин сууж буй улсынхаа хэлийг мэддэг эсэх нь маш чухал байдаг. Солонгос иргэдтэй гэрлэсэн эдгээр охид, эмэгтэйчүүдийн тал орчим хувь нь ихэвчлэн солонгос, англи хэлээр бага зэрэг л ярьдаг гэж хариулсан. Харин дөрвөн эмэгтэйн нөхөр нь монгол хэлээр бага зэрэг ярьдаг юм байна.

Хариулагчдын гэрлэлтийн байдлыг судалж үзэхэд 16 нь гэрлэсэн (баталгаатай), зургаа нь хамтран амьдардаг (баталгаагүй), дөрөв нь хуурамчаар гэрлэсэн (хамт амьдраагүй), үлдсэн дөрөв нь тусдаа амьдарч байгаа (зугтсан) гэж хариулав. Тэдний 19-нь Солонгос нөхрөөсөө хүүхэд төрүүлжээ.

Байршлын хувьд охид, эмэгтэйчүүдийн 13 нь БНСУ-ын Сөүл хотод, 17 нь бусад мужуудад амьдардаг ба зарим нь ямар хот, мужид амьдардагаа ч хэлж мэдэхгүй байв.


Охид, эмэгтэйчүүдийн БНСУ-д гэрлэхээр шилжсэн гол шалтгаанд санхүүгийн бэрхшээл гэсэн хариулт зонхилж байна. Мөн тухайн улсад амьдрах виз авч ажиллах, Монгол дахь гэр бүлээ тэжээх мөнгө явуулах, боловсролдоо зориулж мөнгө хадгалах, монголд жижиг бизнес эрхлэх мөнгөтэй болох зэрэг зорилго багагүй хувийг эзлэж байв.

Хүснэгт 5. БНСУ-д гэрлэхээр шилжин ирсэн шалтгаан

Шалтгаан	Тоо	Хувь
Виз авч Солонгост ажиллахын тулд	26	88.2
Туршлагатай болох гээд	2	5.9
Гэр бүлийнхнийхээ таарамжгүй харьцаанаас зугтаж	2	5.9
Гэр бүлээ тэжээх мөнгө явуулах гээд	18	58.8
Боловсролдоо зориулж мөнгө хадгалах гээд	11	35.3
Монголд жижиг бизнес эрхлэх мөнгөтэй болох гээд	4	11.8
Бусад	2	5.9

Охид, эмэгтэйчүүдийн ихэнх нь (26) Монгол болон Солонгос улсад байдаг зуучлалын алба, зуучлагчаар дамжиж гэрлэсэн байна. Зуучлалын алба, зуучлагчийн талаарх болон гадаадын иргэдтэй гэрлэх талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан зар, найз нөхөд, хамаатнуудаасаа олж авчээ.

Зураг 6. Зуучлагч, зуучлалын албаар дамжиж гэрлэсэн эсэх



Зуучлалын алба, зуучлагчаар дамжиж гэрлэхээр ирсэн дээрх охид, эмэгтэйчүүдийн ихэнхи буюу 18 нь зуучлагч, зуучлалын албаныхантай ямар нэгэн гэрээ хийгээгүй байна. Түүнчлэн “Чамтай гэрлэснээрээ танай нөхөр зуучлагчид мөнгө төлсөн үү” гэсэн асуултанд ихэнх нь (23) “Тийм” гэж хариултыг өгчээ. Зуучлагчид төлсөн нөхрийнх нь мөнгөний хэмжээ нь \$3.000-\$5.000 гэдгийг олон эмэгтэй батлаж байв.

Тэдний ихэнхи нь (19) Монгол улс дахь зуучлалын алба, долоо нь БНСУ дахь зуучлалын алба, нөгөө дөрөв нь найз нөхөд нь танилцуулсанаар анх нөхөртэйгээ уулзсан гэжээ. Зөвхөн найман эмэгтэй гэрлэхээсээ өмнө нөхөртэйгээ дөрөв ба түүнээс дээш удаа уулзсан гэсэн бол зургаа нь 2-3 удаа бусад 16 нь гэрлэхээсээ өмнө нэг удаа л уулзжээ. Энэ нь зуучлах албаар гэрлэж буй эмэгтэйчүүдэд нөхрийгээ таних хугацаа байхгүй байгааг харуулж байна.

“Солонгос улсад ирсэний дараа гэрлэлтээсээ татгалзаж болно гэж зуучлагч эсвэл таны нөхөр эсвэл хэн нэгэн хэлж байсан уу?” гэсэн асуултанд тэдний талаас илүү орчим нь (17) нь “Тийм, би Солонгост ирээд нөхрөө орхино гэж бодож байсан” гэсэн бол бусад нь “Солонгост нөхөртэйгээ амьдарна гэж бодож байсан” гэжээ. Тэдний тал хувь нь хоёр жилийн дотор Солонгосын иргэн болно гэсэн мэдээллийг зуучлагч болон нөхрөөсөө мөн хэн нэгнээс авсан байв. 12 нь Солонгост ирээд хоёр жилийн дотор Солонгосын оршин суугч болно гэсэн ойлголт авчээ.

Хариулагчдын 50 хувь нь паспорт, оршин суух бүртгэл гэх мэт баримт бичгүүдээ өөрийн биедээ хадгалж байгаа гэсэн бол өөрт нь байхгүй гэсэн эмэгтэйчүүд нөхөр, хадмууд мөн Солонгосын зуучлалын албанд хадгалагдаж буй хэмээн хариулсан.

Солонгос иргэдтэй гэр бүл болсон охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь /24/ гэрлэлтэндээ сэтгэл хангалуун биш гэсэн бөгөөд үүнийхээ шалтгааныг муу хүнтэй гэрлэсэн, санаандаа хүрч амьдарч чадахгүй буй, хүний эрхэнд боол шиг байгаа, арчаагүй байдалд байна гэсэн хариултаудаар тайлбарлажээ

Охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь эрхэлсэн ажилгүй, нөхрөөсөө хараат амьдардаг тул санхүүгийн хувьд бие дааж чаддаггүй, Монголд буй ар гэрийнхэндээ мөнгө илгээх боломж бараг үгүй гэж хариулсан.

Солонгос нөхрийнхөө гэрт цэвэрлэгээ, хоол унд хийх, нөхрийнхөө хамаатнуудыг харж асрах, аж ахуйд туслах, нөхөртэйгээ бэлгийн харилцаанд орох зэргийг судалгаанд оролцогчдын тал хувь нь сайн дураар хийдэг гэсэн бол эдгээрийг хүчинд автсаны улмаас хийдэг гэж хариулсан охид, эмэгтэйчүүд цөөнгүй байна.

Архи уух, догшин, хэрцгий ааш гаргах, хүүхэмсэг, халамж муу гэсэн дутагдалтай талууд солонгос нөхрүүдэд элбэг аж. Түүнчлэн нөхөр нь оюун ухааны хомсдолтой, мансууруулах бодис хэрэглэдэг гэсэн хариултыг ч мөн бүсгүйчүүл өгчээ.

Солонгос нөхөртэйгээ амьдарч байх үедээ хоёр эмэгтэй нөхрийнхөө дарамтыг тэвчилгүй 2 удаа оргон зугатаад баригдсан бөгөөд Солонгосын иргэншлийн эрхээ аваад зугатъя гэж бодож байгаагаа илэрхийлсэн.

Доромжлол, шийтгэлийн талаар тодруулахад нөхөр, хамаатнууд нь хэл амаар доромжлох, нөхөр нь бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл үйлдэх явдал тохиолддог нь ажиглагдсан. Хоол ундаа сайн хийгээгүй, тухайлбал солонгос хоол хийгээгүй, утсаар Монгол руу их ярьсан, гадагшаа явлаа, тэнэлээ гэсэн шалтгаануудаар тэднийг гэрт нь хорин цоожлох, сүрдүүлэх, зодох зэргээр шийтгэдэг байна.

Судалгаанд оролцогсдын 60 хувь БНСУ-д очсоноосоо хойш ямар нэгэн өвчнөөр өвчилсөн гэж хариулсан ба тэдний дийлэнх нь ядаргаанд орсон гээд үүнийхээ шалтгааныг сэтгэл санаа тайван биш, стресстэй, ажил хүнд, цаг уур, хоол хүнс таарахгүй байдалтай холбон тайлбарлав. Өвдсөн тохиолдолд эрүүл мэндийн зардлыг нөхөр бүгдийг нь төлдөг гэж нийт судалгаанд хамрагдагсдын 60 хувь буюу 18 нь хариулжээ.

БНСУ-д амьдарч байх хугацаанд тэдний ихэнхэд тусламж дэмжлэг үзүүлж байсан байгууллага, хувь хүн байгаагүй бөгөөд цөөн хэдэн эмэгтэй сүмд болон найз нөхөд дээрээ очиж туслалцаа авч байжээ. Тусламж дэмжлэг авч чаддаггүй гол шалтгаан нь хэлний бэрхшээл, мөн газар орноо сайн мэдэхгүй байгаа явдал юм.

Судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүд бүгд эх орондоо буцахыг хүсэхгүй байна. Шалтгааныг нь тодруулбал, гурван хүн тутмын нэг нь гэрлэсэн, мөн гурван хүн тутмын нэг нь мөнгө олох гэж ирсэн тул Монгол руу буцахгүй гэсэн бол бусад нь Монголд өөрийн гэсэн орон гэр, ажил төрөл, мөнгө олох эх үүсвэр байхгүй, авилга ихтэй гэсэн хариултуудыг тус тус өгчээ.

Тэдний тал нь Солонгос улсад үлдээд ажил хийж, мөнгө олох сонирхолтой гэсэн бол Солонгос нөхөртэйгээ амьдарна гэж 7 эмэгтэй хариулжээ. Харин хоёр нь энэ нөхрөөсөө салаад өөр Солонгос хүнтэй сууна. Хоёр эмэгтэй нөхөртэйгээ хамт амьдарч байгаад энэ улсын иргэншил аваад сална гэсэн бол 5 эмэгтэй энд үлдэхээс өөр арга алга хэмээжээ.


ХҮН ХУДАЛДАХ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨЖ ХАМГИЙН ӨНДӨР МАГАДЛАЛТАЙ, ЭРСДЭЛТЭЙ БҮЛГҮҮД.

Хүн худалдах гэмт хэрэгт өртөж болзошгүй өндөр эрсдэлтэй үүнд, халамжийн төвийн хүүхдүүд, ажил идэвхитэй хайгчид, бага цалинтай үйлдэрийн газарт ажиллагсад, оюутнууд, ахлах ангийнхан гээд нийтдээ 450 хүн энэхүү судалгаанд хамрагдлаа.

Боловсролын хувьд, судалгаанд оролцогчдын дийлэнх буюу гурван хүн тутмын хоёр нь бүрэн, бүрэн бус дунд боловсролтой, дөрвөн хүн тутмын нэг нь дээд боловсролтой, харин үйлдвэрийн газар ажиллагсдын 10 хувь нь ямар нэгэн боловсрол эзэмшээгүй хүмүүс байсан бол ажил идэвхитэй хайгчдын дөнгөж хоёр хувь нь боловсролгүй байв.

Судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүд боловсрол, мэргэжилтэй болохыг хүсэвч сургалтын төлбөр төлөх чадваргүй, ар гэрийн амьдралын боломжгүй байдлаасаа шалтгаалан олдсон ажлыг хийдэг ба голдуу Хятадын хөрөнгө оруулалттай оёдлын үйлдвэрт ажилладаг ажээ. Ажиллаж буй газарт нь хөдөлмөр хамгааллын наад захын шаардлага хангагдаж чаддаггүйгээс гадна ажлын цаг урт, ажил ихтэй үед хонуулж ажиллуулдаг, хөдөлмөрийн үнэлэмж маш багатай байдаг ба үйлдвэрээ хүссэн үедээ хаадгаас шалтгаалан тогтмол ажилтай байж чаддаггүй юм байна.

Зураг 7. Эрсдэлтэй саналыг хүлээж авах байдал, ажил эрхлэлтээр




Судалгаанд хамрагдсан дөрвөн хүн тутмын нэг нь дээд боловсрол эзэмшсэн боловч мэргэжлийнхээ дагуу ажиллах ажлын байр олдохгүйгээс зарим нь үйлдвэрт ажиллаж, мөн нэг хэсэг нь ажил идэвхитэй хайгчдын эгнээнд шилжжээ.

Хүн худалдах гэмт хэргийн талаарх ойлголт мэдлэгийг тандахад талаас илүү хувь нь энэ тухай мэдэхгүй байхад харин үйлдвэрт ажиллагч дөрвөн хүний нэг нь охид, эмэгтэйчүүдийг “хил гарган худалддаг зүйл /арга/” гэж үзсэн бөгөөд энэ тухай мэдээллийг 45.5 хувь нь телевизийн нэвтрүүлгээс, 29.5 хувь нь сониноос олж мэджээ.

Судалгаанд оролцсон үйлдвэрийн газар ажиллагч 10 хүн тутмын нэг нь, ажил идэвхитэй хайгч 20 хүн тутмын нэг нь хүн худалдах гэмт хэрэгт өртсөн найз нөхдийнхээ тухай мэднэ гэжээ. Гэвч хэнээр зуучлуулж, хаашаа явсан, ямар ажил хийж байгаад, хэзээ, ямар арга замаар эх орондоо ирсэн талаар хэн нь ч мэдэхгүй байлаа.

Хариулагчдын ирээдүйн талаар асуухад 17-19 насныхны 42.0 хувь нь боломжийн ажилтай, мөнгөтэй болох, 22,2 хувь нь сайн хүнтэй суух, 25.0 хувь нь гадаадын олон орноор явах, суралцах сонирхолтой гэж хариулсан бол 22-24 насныхны 35.0 хувь нь гадаадад ажиллаж, суралцан тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай болоод эх орондоо эргэн ирж мэргэжлээрээ ажиллах буюу өөрийн гэсэн ямар нэгэн ажлын байртай болно гэж хариулж байлаа.

Зураг 8. Оюутан, сурагчдын ХХГХ-т өртөх эрсдэлийн талаар



ЕБДС төгсөж буй сурагчдын 88 хувь нь сургуулиа төгсөөд их, дээд сургуульд суралцах хүсэлтэй байгаа бол оюутнуудын 82 хувь нь мэргэжлээрээ ажиллах хүсэлтэй ажээ.

Оюутнууд төгсөөд мэргэжлээрээ ажиллах сонирхолтой боловч дараах болзлуудыг хэн нэгний зүгээс тавибал гадагшаа гарч ажиллахад татгалзахгүй гэжээ. Үүнд: 48.5 хувь нь бичиг баримт, визтэй холбоотой асуудлыг шийдэж өгвөл, 42.4 хувь нь өндөр цалинтай ажилд оруулна гэвэл, 34 хувь нь гадагшаа гарахад шаардлагатай зардлыг нь даана гэвэл, 39.4 хувь нь холбогдох бүх зардлыг нь зуучлагч өөрөө даан очоод ажил хийж зардлаа төлөх боломжтой гэвэл зөвшөөрнө гэжээ.

Харин ахлах ангийн хоёр сурагч тутмын нэг нь очоод ажлаа хийж зардлаа төлөх боломж олговол, мөн виз, бичиг баримтын асуудалд туславал дээрх саналыг хүлээж авах боломжтой гэж үзжээ.

Эмэгтэй оюутнуудын 13.1 хувьд, дөрвөн эмэгтэй сурагчдад сурангаа ажиллах, өндөр цалинтай ажилд оруулах, гадаадад хүүхэд асруулах, богино хугацаанд ахиухан мөнгө хураах боломжтой гэсэн саналыг судалгаа явагдахаас өмнө хэн нэгний зүгээс тавьж байжээ.

Мөн судалгаанд хамрагдсан эмэгтэй оюутнуудын 10.1 хувьд нь, сурагчдын 5 хувьд Монголд өндөр цалинтай боломжийн ажилд оруулж өгье гэсэн саналыг эмэгтэй найз, таньдаг эгч нараас нь, гадаад хүний зүгээс хүүхэд асрагч, бар, зочид буудалд зөөгч, үйлчлэгч хийх саналуудыг тавьж байжээ.

Судалгаанд оролцсон оюутнуудын 17.7 хувь, сурагчдын 21 хувь нь хүн худалдах гэмт хэрэгт өртсөн ойр дотны хэн нэгнийг мэднэ гэжээ.

Оюутнууд, ахлах ангийн сурагчдын 87.5 хувь нь “үйлчилгээний газар ажиллагсад”, 48.5 хувь нь “оюутнууд” хүн худалдах гэмт хэрэгт өртөх хамгийн их эрсдэлтэй гэж үзсэн бол ахлах ангийн сурагчдын 29 хувь нь “оюутнууд”, 19 хувь нь “ахлах ангийн сурагчид болон биеэ үнэлэгчид, үйлчилгээний газарт ажиллагсад”, 16 хувь нь “хараа хяналтгүй хүүхдүүд” хамгийн их өртөх эрсдэлтэй гэж хариулжээ.

Судалгаанд оролцсон ахлах ангийн сурагчдын 85 хувь, оюутнуудын 62 хувь нь хүн худалдах гэмт хэргийн талаар мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс авсан байна.

Хүн худалдах гэмт хэргийг хүнийг бусдад худалдаж ашиг олох, ноцтой гэмт хэрэг гэж дийлэнхи нь ойлгож байсан ба ашиг олохын тулд муу

хүмүүсийн хийж буй ажил, хүний эрхийг зөрчсөн үйлдэл, маш аюултай зүйл гэх мэтээр тодорхойлж байхад 20 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ. Үүнээс үзэхэд оюутнууд, ахлах ангийн сурагчид энэ талаар анхан шатны мэдээлэлтэй болох нь харагдаж байна.

Судалгаанд оролцсон 2-р курсын оюутнуудын 50 хувь, 3-р курсийн оюутнуудын 66 хувь, 4-р курсийн оюутнуудын 84.6 хувь тус тус гадаадын аль нэг улс руу хэн нэгний тусалцаатайгаар явах сонирхолтой юм байна.

15 настай сурагч охидын 41 хувь, 16 настай охидын 24 хувь, 17 настай охидын 35 хувь нь гадаад явж сурч ажиллахдаа бусдын тусламжийг авах сонирхолтой гэжээ.


Судалгаанд хамрагдсан таван хүүхдүүдэд насанд хүрэгчдийн зүгээс гадаадад ажил хийх санал тавьсан бөгөөд харин гурван хүүхэд тутмын нэгд дотоодод мөнгө олох ажил санал болгож байжээ. Тухайлбал баар цэнгээний газар ажиллах, хөдөө мал маллах, микро автобусанд кондуктор хийх, машин угаах зэрэг саналууд байсан ба хоёр хүүхэд л уг саналыг хүлээж авчээ.

Судалгаанд оролцсон халамжийн төвийн хүүхдүүдийн 40 хувь нь хүүхдийг эцэг, эхээс нь өөр хүн гадаадад авч явдаг тухай сонссон бөгөөд тэднийг цалингүй ажиллуулах, худалдах, хулгай хийлгэх, эд эрхтнийг нь авах, биеийг нь үнэлүүлэх, боол болгох зорилгоор авч явдаг гэж хариулснаас харахад тэд хүн худалдах гэмт хэргийн талаар судалгаанд хамрагдсан бүх бүлгүүдээс илүү мэдээлэлтэй байгаа нь харагдсан.

Мөн гадаад руу хэн нэгэн хүн хүүхдийг хуурч мэхлэн авч явсан тухай 14.5 хувь нь мэддэг бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслээс болон найзаасаа энэ тухай сонсжээ.

Халамжийн төвд амьдарч байгаа хүүхдүүдийн 35.7 хувь нь хэн нэгэн гадаадын аль нэг улс руу явахад бичиг баримт, зардалд туслан, цалингаас нь төлбөрөө төлүүлэх боломжтой гэсэн санал тавибал хүлээж авахаар хариулж байгаа нь өндөр эрсдэлтэй бүлэг болохоо харуулж байна.

Санал хүлээж авахыг зөвшөөрсөн халамжийн төвийн хүүхдүүдийн дийлэнх мөнгөтэй болж, өөрийн гэсэн орон гэртэй, боловсролтой болохыг нөгөө хэсэг нь гадаадад гарч үзэх, сайхан амьдрахыг хүсэж байгаа тул дээрх саналыг хүлээж авна гэдгээ илэрхийлжээ.

Зураг 9. Хүүхдүүдийн ирээдүйн зорилго

Хүн худалдах гэмт хэргийн талаар судалгаанд хамрагдсан халамжийн төвийн хоёр хүүхэд тутмын нэг нь сонссон байсан нь бусад бүлгүүдээс илүү их мэдээлэлтэй байгааг нотолж байна. Тэд ашиг олохын тулд хүүхдийг албадлагаар ажил хийлгэх, биеийг нь үнэлүүлэх, хулгай хийлгэх, өрийн барьцаа болгох, ямар ч цалин хөлсгүй боолын ажил хийлгэх, секс үйлчилгээ хийлгэх, зарцлах, эд эрхтэнг нь авах, хуурч мэхлэхийг хэлнэ гэжээ.

Гадаадад очоод хүнд, хэцүү байдалд орвол хэнд хандах вэ гэж асуухад судалгаанд оролцсон хүүхдүүдийн 42 хувь нь хэнд ч хандаж чадахгүй гэж хариулжээ.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаанаас бид дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хүн худалдах гэмт хэрэг Монгол улсад бодитоор бий болж, өнгөрсөн гурван жилийн хугацаанд 21 гэмт хэрэгт хохирогч гомдлоо гаргаж, хууль хяналтын байгууллагад хандсан ч долоон хэрэгт Эрүүгийн хэрэг үүсгэгдэн нэг л хэрэг хуулиар эцэслэн шийдвэрлэгдсэн нь хууль эрхзүйн орчин оновчтой бус байгааг харуулж байна.
- Нийгэмд хүн худалдах гэмт хэргийн тухай ойлголт нь охид, эмэгтэйчүүдийн биеэ үнэлэх явдалтай салшгүй холбоотойгоор ойлгогдож, ёс суртахууны хувьд тэднийг буруутгадаг нь хохирогчдын эрхийн хамгаалалтанд сөргөөр нөлөөлж байна. Ялангуяа хүн худалдах гэмт хэргийн гол шинж тэмдэг болох эмзэг байдлыг урвуулан ашиглах, хуурч мэхлэх, бичиг баримтыг хурааж авах, өрийн боол болгон дарамтлах асуудал бараг хөндөгддөггүйгээс хохирогчид хуулийн байгууллагад хандахаасаа ичиж зовж байна.
- Охид, бүсгүйчүүд харийн нутагт бусдын золиос болон худалдагдаж, эх орондоо эргэн ирж тодорхой хугацааны дараа дахин тэр улсыг зорьж, найз нөхөд, ах дүү нараа дагуулан явж өөрсдөө зуучлагч, элсүүлэгчийн үүрэг гүйцэтгэж гинжин холбоонд орж байна.
- Хүн худалдах гэмт хэргийн хохирогчид саун, массажны газар, караоке, диско клуб, шөнийн цэнгээний газар нэрэн дор далдлагдсан “янхны газруудад” бэлгийн мөлжлөгт ашиглагдаж байна.
- Хохирогчдын нэлээд хэсэг нь хэвлэл мэдээллээр явуулж буй зарын дагуу хандаж, эрсдэлд орж байна.
- Солонгосын иргэнтэй гэрлэж буй эмэгтэйчүүдийн хүүхдэд оршин суух зөвшөөрөл өгдөггүйгээс хүүхдээ өөр дээрээ авахын тулд Солонгос иргэдэд үрчлүүлэх маягаар хүүхдээ авч байна.
- Энэ гэмт хэрэг нь зөвхөн хилийн чанадад төдийгүй дотоодод бас үйлдэгдэж байгаа ч хүн худалдах гэмт хэрэг, биеэ үнэлэлт хоёрын ялгааг тэр бүр ойлгодоггүйгээс зөвхөн гадаадад л үйлдэгддэг мэтээр ойлгох явдал түгээмэл байна.
- Асрамж, халамжийн төвд байрлаж буй хүүхдүүд болон оюутнууд, ахлах ангийн сурагчид, ажил идэвхитэй хайгчид, үйлдвэрийн газар ажиллагсдын ихэнх нь гадаадад гарч ажиллаж, сурах хүсэлтэй бөгөөд хэн нэгэн санал тавьсан тохиолдолд хүлээж авах боломжтой гэж

үзэж буй тохиолдол өндөр байна. Энэ нь Хүн худалдах гэмт хэргийн талаар ойлголт, мэдлэг хангалтгүйгээсээ шалтгаалан өндөр эрсдэлд орж болох бүлэг гэж үзэж болохоор байна.

- Хүн худалдах гэмт хэргийн хохирогч охид, эмэгтэйчүүд эрүүл мэндийн эрсдэлтэй байдалд байна. Өвчилсөн үедээ тэд өөрсдийгөө дур мэдэн эмчлэх нь түгээмэл. ДОХ/БЗХӨ-ний шинжилгээнд хамрагдах, хамгаалах хэрэгсэл хэрэглэх явдал хангалтгүй. Үйлчлүүлэгчийн хүссэнээр ажилладаг тул зарим тохиолдолд бэлгэвчгүй хавьталд орж, өөрийгөө эрсдэлд оруулж байна.
- Хүн худалдах гэмт хэргийг үйлдэгчид хохирогчоо элсүүлдэг нэг хэлбэр нь баар, саун, цэнгээний газрууд юм. Өнөөдөр зөвхөн Улаанбаатар хотод 250 гаруй зочид буудал, 700 гаруй баар цэнгээний газрууд үйл ажиллагаагаа явуулж байгаа гэдэг ч энэ нь бүрэн хэмжээнд бүртгэгдсэн тоо биш юм. Эдгээр үйлчилгээний газруудад сайн ажиллавал гадаадад явуулж сургана, ажиллуулна гэсэн амлалтанд нь хууртан ажиллаж буй эмэгтэйчүүд цөөнгүй байна.
- Хүүхэд үрчлэлтийн асуудлыг олон байгууллага хариуцаж байгаа ч хяналт хийх тогтолцоо нь зөвхөн гадаадад үрчлэгдсэнээр хязгаарлагдаж, дотоодод хүүхэд үрчлэлтийн асуудал тодорхойгүй байгаагаас сөрөг үр дагавар үүдэн гарах боломжтой гэж үзлээ. Хэдийгээр Гаагийн конвенцид нэгдэн орж, холбогдох хууль тогтоомжиндоо тусгасан ч зургаан сараас дээш хугацаагаар оршин сууж буй гадаадын иргэд Монгол улсын иргэдийн нэгэн адил хүүхэд үрчлэх эрхтэй болж байгаа нь бодууштай. Мөн хүүхэд үрчлэлтийн талаар тайланг олон нийтэд мэдээлдэггүй, мэдээллийг нууцалж байгаа нь анхаарал татаж байна.
- Худалдаалагдсан хохирогчид үзүүлэх тусламжийн үйл ажиллагаа, урьдчилан сэргийлэх ажлууд дутмаг. Өөрөөр хэлбэл, үйлдлийн дараа хариу өгөх байдлаар явагдаж, худалдагдсан хүмүүсийн хойноос нэхэмжлэх шаардлагыг бий болгоогүй, худалдагдсан хохирогчдыг эх орондоо авч ирэх талаар үйл ажиллагаа явуулдаггүй нь тэдний эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна.
- Гадаадад ажиллах хүчин зуучилж буй албан ёсны зөвшөөрөлтэй байгууллагууд дийлэнхдээ эрчүүдийг зуучилдгаас охид, эмэгтэйчүүд хууль бус аргыг сонгоход хүрч байна.
- Монгол улсад 90 гаруй төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа гэх боловч энэ талаар олон нийтэд ойлголт, мэдлэг дутмаг, сурталчилгаа хангалтгүй, хөтөлбөр нь бүрэн хэмжээнд хэрэгждэггүй нь хүний эрхийг хангах, хамгаалах, үндсэн эрхүүдээ ч эдэлж чадахгүй байдалд хүргэж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны үндсэн үр дүнд тулгуурлан бид дараах санал зөвлөмжийг холбогдох байгууллага, хууль тогтоогчид, бодлого боловсруулагчид, бүх шатны хууль хяналтын болон боловсролын байгууллага, нийт ард иргэддээ зориулан гаргаж байна. Энэ чиглэлээр явуулах үйл ажиллагаандаа урьд батлагдсан Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр, Өсвөр үе, залуучуудын үндэсний хөтөлбөр болон бусад хөтөлбөр, бодлогуудад тусгагдсан үндсэн чиглэл, үйл ажиллагааг нэг бүрчлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төр засгийн түвшинд

1. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалыг хангаж, ХХГХ-ийн зуучлагч, гэмт хэрэгтнүүдийг хуулийн хариуцлагад татах зорилгоор үндэстэн хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар нэн даруй зохих арга хэмжээ авах;
2. Хилийн шалган нэвтрүүлэх боомтууд дээр бүртгэл, хяналтын ажиллагааг сайжруулах. Холбогдох байгууллагуудыг бүртгэлийн нэгдсэн системд оруулах. Ялангуяа хүүхдийн бүртгэлийн ажилд гарсан шинэ санааг улам бүр хөгжүүлэн, компьютерийн нэгдсэн системд оруулах;
3. БНХАУ-ын Макао, Хонг-Конг, Бээжин, Эрээн, Хөх хотууд, БНСУ-д суугаа өөрийн улсын ЭСЯ, хүний эрхийн чиглэлээр ажилладаг тухайн орны байгууллагуудыг түшиглэн хохирогчид зөвлөгөө, туслалцаа үзүүлэх мэргэжлийн нэгжийг байгуулах. Энэ чиглэлээр ажилладаг байгууллагуудтай хамтран сүлжээгээр ажиллах боломжийг бий болгох;
4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй заруудад хяналт тавих механизмыг бий болгох, холбогдох хуулинд өөрчлөлт оруулах;
5. Хүйсийн талаарх тогтсон үзэл хандлага, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах үзлийг үгүй хийх. Охид, эмэгтэйчүүдийг сексийн объект мэт үзэж, бэлгийн мөлжлөг, хүн худалдах гэмт хэргийн хохирогч болгож буйд анхаарлаа хандуулан, нийгэм дэх хүйсийн тэгш бус байдал, эмэгтэйчүүдийг дорд үзсэн үзэл хандлагын эсрэг үйл ажиллагааг өргөн хүрээнд явуулах, холбогдох хууль тогтоомжинд тусгах;

6. Эрүүгийн хуулийн холбогдох заалтыг боловсронгуй болгох, зуучлагчийн талаарх асуудлыг тусгаж өгөх, биеэ үнэлэгчийг худалдаж авч буй хүмүүст хариуцлага тооцдог болох;
7. Албан болон хувийн хэргээр гадаадад зорчигчдын эрхийг хамгаалах, хохирсон эрхийг сэргээх, туслалцаа үзүүлэх, аюулгүй байдлыг хангах тал дээр тухайн улсад суугаа ЭСЯ, консулын газар санаачилгатай ажиллах, тэдэнд үүрэг хүлээлгэх, ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулах;
8. Гэр бүлийн хуулинд гэр бүл зуучлалын талаар нарийвчлан тусгаж өгөх, гэр бүл зуучилж буй хувь хүмүүс байгууллагыг цэгцэлж, хариуцлагын механизмыг тодорхой болгох;
9. ХХГХ-т өртөх магадлал нь хохирогчдын эдийн засаг, санхүүгийн эмзэг байдалтай холбоотой байна. Хохирогчдын дийлэнхи нь үйлчилгээний газар ажиллагсад, их дээд сургуульд суралцаж буй залуучууд, сургууль төгссөн боловч мэргэжлээрээ ажиллаж чадахгүй эмэгтэйчүүд байгаад анхаарч, суралцахын зэрэгцээ ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, түүнчлэн ажиллагсдын хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх;
10. Худалдаалагдсан эмэгтэйчүүд хүүхдүүдийн хамгааллын гол суурь нь эрхэнд тулгуурласан байх ёстой зарчмыг хууль, хөтөлбөр, үйл ажиллагаандаа удирдлага болгох. НҮБ-ын “Хүн дамлан худалдаалахын эсрэг протокол” болон олон улсын бусад стандартыг үндэсний хууль тогтоомжид тусган нэмж оруулах. Хуульчдыг ХХГХ, хохирогчийн сэтгэл санаа болон аюулгүй байдлын талаар нэгдмэл ойлголттой болгох. Хохирогчийн эрхийн хамгаалалтын талаар нэн даруй шинэчлэлт хийх;
11. Хүн худалдах гэмт хэргийн эсрэг хууль, бодлого, хөтөлбөр болон хөндлөнгийн оролцоонуудад хүний эрхийг хангах талаар тусгагдсан эсэхэд хяналт тавих механизмыг бий болгох;
12. Хүн худалдах гэмт хэрэгт өртсөн хүмүүсийг сэтгэл санааны хувьд дэмжих, нөхөн сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор хүн худалдаалагчдын хөрөнгийг хураах талаар хуулийн заалт бий болгох. Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн зохих заалтыг хэрэгжүүлэх;
13. Хууль боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагаанд хүн худалдах гэмт хэрэгт өртөн хохирогч болж байсан хүмүүстэй зөвлөлдөх, тэдний саналыг сонсож тусгаж байх;

14. ХХГХ-ийн хохирогчдыг эх оронд нь нэн даруй авч ирэх талаар яаралтай арга хэмжээ авах, бусад улсуудтай энэ чиглэлээр хамтарч ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах;
15. Монгол улсад ДОХ/ХДХВ-ын тархалт өсөх төлөв байдалтай байгаатай холбогдуулан хилээр гарч, орж байгаа дотоод, гадаадын иргэдийг заавал шинжилгээнд хамруулан, санамж өгч байх.

Төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн түвшинд

1. Хүн худалдаалагч нарыг хуулийн хариуцлагад татах явцад хохирогчдыг хууль, өмгөөллийн болон бусад тусламжаар хангах. Хуулийн процедурын явцад худалдагдсан хүмүүс, гэрчүүдийн нэр хаяг, аюулгүй байдлыг хангах;
2. Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийг бүрэн хэмжээнд хэрэгжүүлэх
3. Гадаадад аялагчдад зориулсан урьдчилан сэргийлэх мэдээлэл, холбогдох байгууллагуудын хаяг, санамж зэргийг өөрийн улсын галт тэрэг, нисэх онгоцны буудлууд дээр байрлуулах;
4. Хохирогчийн нууцыг хамгаалах, түүний эрхийг хамгаалахдаа хувийн нууцыг задруулахгүй байх талаар тухайн мэргэжлийн бүлгүүд ёс зүйгээ баримтлан хуулийн хүрээнд ажиллах. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүний нэр төр гутаах зорилготой мэдээллийг гаргуулахгүй байх, хохирогчийн эрх ашгийг эн тэргүүнд тавьж ажиллах;
5. Судалгаанд тодорхойлогдсон эрсдэлтэй бүлгүүд болох ахлах ангийн сурагчид, оюутнууд, ажилгүй, ажил идэвхитэй хайгчид, халамжийн төвийн хүүхдүүд, үйлдвэрийн газар ажиллагсдыг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдлээс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авах;
6. Худалдаалагдсан хүмүүсийг цагаачлалын статустай эсэхээс үл хамааран гэмт хэрэгтэн гэж тооцохыг болих ба тэднийг хохирогч болон даван туулагч нар гэж үзэх;
7. ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх түвшинд сургалт, сурталчилгааны олон хэлбэрээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах. Ялангуяа эрсдэлтэй бүлгийнхэнд зориулсан үйл ажиллагааг нэн даруй эхлүүлэх. Энэхүү гэмт хэргийн хор уршиг, үр дагавар, цаашилбал, хүн худалдаалах гэмт хэргийн

гол золиос болох эрсдэл өндөр байгааг ойлгуулахад чиглэгдсэн бүх талын арга хэмжээг зохион байгуулах;

8. ХХГХ-ийн хохирогч охид, эмэгтэйчүүд эрүүл мэндийн хувьд өндөр эрсдэлтэй байдалд байгааг анхаарч тэднийг ДОХ/БЗХӨ-ний шинжилгээнд тогтмол хамруулах. Энэхүү өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хамгаалах бүх талын сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд хамруулж байх, тэдэнд зориулсан тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх;
9. Гадаадын иргэдтэй гэр бүл болоход зуучлал, брокерийн асуудлыг шийдэж, хуулинд тусгаж өгөх. Зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй хувь хүмүүс, байгууллагуудын үйл ажиллагааг нэн даруй хаах, зохих бусад арга хэмжээг авах;
10. Хохирогчдод зөвлөгөө өгөх, мэдээлэл авах “Итгэлтэй утас”, “Итгэлтэй шуудан” ажиллуулах

Иргэд, хувь хүний түвшинд

1. Хүн худалдах гэмт хэргийн талаар мэдлэгтэй болох, холбогдох байгууллага, мэдээллийн эх үүсвэрээс баталгаажуулж байх;
2. Гадаад оронд сурч, ажиллахаар шийдсэн бол зөвхөн албан ёсны зөвшөөрөлтэй байгууллагад хандах, тухайн очих гэж буй сургууль, албан газрын болон зуучлагчийн хаягийг авч, холбоо барьж баталгаажуулах;
3. Элдэв төрлийн зар, таньж мэдэх хүмүүсээр дамжуулан дотоод, гадаадад өндөр цалин хөлс, боломжууд амласан тохиолдолд эрсдэлд орохгүйн тулд итгэлтэй байгууллага, хувь хүнээс асууж баталгаажуулж, гэр бүлийн гишүүдтэйгээ зөвлөж шийдвэрээ гаргаж байх;
4. Эцэг, эхчүүдийн зүгээс хүүхэддээ тавих анхаарал халамжаа нэмэгдүүлж, хариуцлагаа өндөржүүлэх;
5. Хэрэв сурч, ажиллахаар гадаад оронд очсон бол заавал өөрийн улсын ЭСЯ, Консулын газарт очиж бүртгүүлж, тусламж, дэмжлэг авч байх.